

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/162/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М. Батсуурь

Утас: 70453317

Аудитын менежер: М. Бат-Амгалан

Утас: 70453799

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит

ХХК-ийн аудитор: Г.Баялаг

Утас: 99023656

Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХЯРГАС СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Я.ЦЭЭСҮРЭН ТАНАА

2023.02.24 № УВА-2023/162/НА -СМА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хяргас сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200000155

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,247,206.63</u>	<u>97,915,493.95</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	18,013,901.79
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	18,013,901.79
3121	Төгрөг	00.00	18,013,901.79
31211	Төрийн сангийн харилцах	00.00	18,013,901.79
33	АВЛАГА	2,554.72	0.00
33500	Бусад авлага	2,554.72	0.00
33510	Байгууллагаас авах авлага	2,554.72	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	67,244,651.91	79,901,592.16
354	Хангамжийн материал	67,244,651.91	79,901,592.16
35420	Аж ахуйн материал	64,066,771.66	77,536,919.16
35460	Хүнсний материал	2,505,480.25	2,364,673.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>564,686,264.81</u>	<u>543,436,799.87</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	564,686,264.81	543,436,799.87
392	Биет хөрөнгө	551,260,264.81	530,010,799.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	559,033,818.97	567,033,818.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	-60,988,046.32	-83,406,682.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,072,000.00	49,224,935.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,998,742.61	-27,726,942.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,076,180.00	43,629,080.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,856,145.11	-31,025,275.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,771,406.00	32,771,406.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,559,406.12	-22,198,739.47
39217	Ном	1,709,200.00	1,709,200.00
393	Биет бус хөрөнгө	13,426,000.00	13,426,000.00
39301	Програм хангамж	212,400.00	212,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-212,400.00	-212,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,426,000.00	13,426,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>631,933,471.44</u>	<u>641,352,293.82</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>631,933,471.44</u>	<u>641,352,293.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	631,933,471.44	641,352,293.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	218,840,999.00	218,840,999.00
51101	Өмч: - төрийн	218,840,999.00	218,840,999.00
512	Хуримтлагдсан үр дүн	285,891,260.26	295,310,082.64
51210	Өмнөх үеийн үр дүн	285,891,260.26	285,891,260.26
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,418,822.38

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	127,201,212.18	127,201,212.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	631,933,471.44	641,352,293.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	341,318,100.00	363,988,082.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,235,000.00	29,495,982.50
120	Нийтлэг татварын бус орлого	29,235,000.00	29,495,982.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,235,000.00	29,495,982.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,235,000.00	29,495,982.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,652,100.00	334,492,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	289,221,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	289,221,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,472,100.00	45,270,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,472,100.00	45,271,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	347,110,162.76	354,569,260.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,110,162.76	354,569,260.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,820,262.42	354,568,932.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,767,639.31	210,544,785.91
210101	Үндсэн цалин	156,789,649.31	159,613,911.29
210102	Нэмэгдэл	19,838,811.00	42,070,361.00
210104	Урамшуулал	17,395,803.00	8,860,513.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,212,639.63	26,445,412.26
210201	Тэтгэврийн даатгал	17,452,630.41	17,657,923.12
210202	Тэтгэмжийн даатгал	1,990,318.20	2,087,611.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,592,245.60	1,864,588.80
210204	Ажилгүйдлийн даатгал	379,768.82	447,890.36
210205	Эрүүл мэндийн даатгал	3,797,676.60	4,387,398.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,738,040.00	27,994,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,565,250.00	2,746,024.00
210302	Түлш, халаалт	25,023,410.00	25,093,476.00
210303	Цэвэр, бохир ус	149,380.00	155,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	3,725,660.00
210401	Бичиг хэрэг	0.00	189,700.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	3,335,960.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	200,000.00
2105	Нормативт зардал	13,146,241.05	40,077,737.25
210502	Хоол, хүнс	11,565,941.05	40,077,737.25

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	702,100.00	2,150,200.00
210604	Урсгал засвар	702,100.00	2,150,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,085,000.00	390,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,000.00	390,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,272,083.51	43,240,636.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,254,637.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,735,086.00	2,030,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,536,997.51	38,955,299.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,289,900.34	327.76
2134	Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,789,900.34	327.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	327.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,792,062.76	9,418,822.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,792,062.76	9,418,822.38

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	312,083,100.00	334,492,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	312,083,100.00	334,492,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	289,221,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	289,221,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,472,100.00	45,270,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,472,100.00	45,270,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	312,083,100.00	314,798,198.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,083,100.00	314,798,198.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,793,199.66	314,798,198.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,601,496.31	210,805,453.91
210101	Үндсэн цалин	156,705,655.31	159,874,579.41
210102	Нэмэгдэл	22,754,276.00	42,070,361.00
210104	Урамшуулал	17,395,803.00	8,860,513.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,628,463.35	26,182,189.54
210201	Тэтгэврийн даатгал	14,622,651.69	17,871,672.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,591,159.28	2,093,176.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,272,767.41	1,674,680.96
210204	Ажилгүйдлийн даатгал	285,444.09	406,614.79

210205	Эрүүл мэндийн даатгал	2,856,440.88	4,136,044.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,686,840.00	27,322,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,565,250.00	2,746,024.00
210302	Түлш, халаалт	24,972,210.00	24,421,076.00
210303	Цэвэр, бохир ус	149,380.00	155,000.00
2105	Нормативт зардал	12,208,600.00	39,936,930.00
210502	Хоол, хүнс	11,655,700.00	39,936,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,300,000.00	2,135,200.00
210604	Урсгал засвар	800,000.00	2,135,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,085,000.00	390,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,000.00	390,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,037,000.00	8,025,997.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,295,997.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,037,000.00	2,730,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,289,900.34	327.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	500,000.00	327.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	327.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	19,693,901.79
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	1,680,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,680,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1,680,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	1,680,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-1,680,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	18,013,901.79
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	18,013,901.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	218,840,999.00	127,201,212.18	285,891,260.26	631,933,471.44

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,840,999.00	127,201,212.18	285,891,260.26	631,933,471.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,418,822.38	9,418,822.38
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,840,999.00	127,201,212.18	295,310,082.64	641,352,293.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	289,221,500.00	271,207,598.21	18,013,901.8	93.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	289,221,500.00	271,207,598.21	18,013,901.8	93.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,221,500.00	271,207,598.21	18,013,901.8	93.8%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,789,100.00	196,749,480.21	14,039,619.8	93.3%
210101	Үндсэн цалин	173,370,800.00	148,319,525.21	25,051,274.8	85.5%
210102	Нэмэгдэл	35,021,700.00	40,706,811.00	-5,685,111.0	116.2%
210104	Урамшуулал	2,396,600.00	7,723,144.00	-5,326,544.0	322.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,488,100.00	24,425,191.00	1,062,909.0	95.8%
210201	Тэтгэврийн даатгал	17,344,100.00	16,676,913.21	667,186.8	96.2%
210202	Тэтгэмжийн даатгал	2,036,000.00	1,952,616.41	83,383.6	95.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,628,800.00	1,562,233.16	66,566.8	95.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	407,200.00	378,502.85	28,697.2	92.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,072,000.00	3,854,925.37	217,074.6	94.6%
2105	Нормативт зардал	42,645,800.00	39,936,930.00	2,708,870.0	93.6%
210502	Хоол, хүнс	42,645,800.00	39,936,930.00	2,708,870.0	93.6%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	390,000.00	202,000.0	65.8%

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	390,000.00	202,000.0	65.8%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,706,500.00	9705997.00	503.0	99.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,976,500.00	6,975,997.00	503.0	99.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,730,000.00	2,730,000.00	0.0	100%
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж			0.0	0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	289,221,500.00	289,221,500.00	0.0	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	289,221,500.00	289,221,500.00	0.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	289,221,500.00	289,221,500.00	0.00	100%
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.0	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	18,013,901.79	-18,013,901.8	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00		
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16.00	16.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00		
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00		
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)				

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,270,600.00	45,270,272.24	327.76	99.90%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,270,600.00	45,270,272.24	327.76	99.90%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,270,600.00	45,270,272.24	327.76	99.90%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,056,100.00	14,055,973.70	126.30	99.90%
210101	Үндсэн цалин	14,056,100.00	11,555,054.20	2,501,045.80	82.20%
210102	Нэмэгдэл	0	1,363,550.00	-1,363,550.00	0
210104	Урамшуулал	0	1,137,369.50	-1,137,369.50	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,757,200.00	1,756,998.54	201.46	99.90%
210201	Тэтгэврийн даатгал	1,194,900.00	1,194,759.54	140.46	99.90%
210202	Тэтгэмжийн даатгал	140,600.00	140,559.74	40.26	99.90%
210203	ҮОМШӨ-ний даатгал	112,400.00	112,447.80	-47.80	100%

210204	Ажилгүйдлийн даатгал	28,100.00	28,111.94	-11.94	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	281,200.00	281,119.52	80.48	99.90%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,672,100.00	27,672,100.00	0.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	3,100,000.00	2,746,024.00	353,976.00	88.60%
210302	Түлш, халаалт	24,422,100.00	24,421,076.00	1,024.00	99.90%
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	155,000.00	-5,000.00	103.30%
210304	Байрны түрээс	0	350,000.00	-350,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,785,200.00	1,785,200.00	0.00	100%
210604	Урсгал засвар	1,785,200.00	1,785,200.00	0.00	100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,270,600.00	45,270,272.24	327.76	100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,270,600.00	45,270,272.24	327.76	100%
320001	Орон нутгийн төсвөөс	45,270,600.00	45,270,272.24	327.76	100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Хяргас сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тайлант онд тус цэцэрлэг нь "Багш бүр хичээлийн бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулан, хүүхдийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах" гэсэн зорилго дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслацгаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,418.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	18,013.9	18,013.9
Авлага	2.5	0.0	0
Бараа материал	67,244.6	79,901.6	12,657.0
Үндсэн хөрөнгө	564,686.3	543,436.8	-21,249.5
Нийт хөрөнгө	631,933.5	641,352.3	9,418.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	631,933.5	641,352.3	9,418.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	631,933.5	641,352.3	9,418.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18,013.9 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 79,901.6 мянган төгрөг болж 12,657.0 мянган төгрөгөөр буюу 28.9 хувь өссөн байна. Үүнд аж ахуйн материалын худалдан авалт голлон нөлөөлсөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 543,436.8 мянган төгрөг болж 21,249.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд 1,680.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, 16,025.8 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар хүлээн авсан, тайлант хугацааны элэгдлийн зардалд 38,955.3 мянган төгрөг тооцсон байна.

Энэ онд харилцагч байгууллагуудтай холбоотой өр төлбөргүй болох нь тооцооны үлдэгдлээр баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 641,352.3 мянган төгрөг болж 9,418.8 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,441,884.1 мянга төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,091,425.4 мянган төгрөгөөр бууруулж 305,187.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,270.6 мянга, нийт 350,457.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байдлаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 350,457.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 305,187.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,270.6 мянга, нийт 350,457.7 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 316,475.7 мянган төгрөг буюу 90.3 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 18,013.9 мянган төгрөгөөр хэмнэж ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	42,645.8	39,936.9	2,708.8	93.6%

2	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,680.5	1,680.0	500.0	99.9%
3	Боловсролын байгууллагын багш,	800.0	800.0	0	100%
4	Боловсролын стандарт, сургалтын орчин	212,637.2	200,546.0	12,091.2	94.3%
5	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	30,658.0	27,444.6	3,213.3	89.5%

Цэцэрлэгийн хүүхдийн хоол хөтөлбөр, арга хэмжээний хувьд өвлийн улиралд ханиад томуу дэгдэлттэй холбоотойгоор, мөн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын өвлийн амралтын хугацаа эхлэх үед хүүхдийн ирцийн хувь төлөвлөсөн хэмжээнээс эрс буурсантай холбоотойгоор 2,708.8 мянган төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн байна.

Боловсролын стандарт, сургалтын орчин болон сургалтын хэвийн орчин гэсэн хоёр хөтөлбөр, арга хэмжээний 15,304.5 мянган төгрөгийн хэмнэлт нь үндсэн болон нэмэгдэл цалингийн зардалтай холбоотой үүссэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баялаг, аудитор С.Эрдэнэчимэг, Ч.Сэлэнгэ нар гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Хяргас сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ариун төгс оршихуй аудит ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан үр дүнгийн тайлангийн нийт зардал 305,187.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,052.0 мянган

төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан. Гүйцэтгэлийн шатанд энэхүү нөхцөл байдал оршин байхгүй болсон учир дахин шинэчлэн тогтоосон болно. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 354,569.3 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 3,545.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,836.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 117, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хяргас сумын Цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогыг нарийвчлан тусгагдаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа нь харилцан адилгүй ялгаатай байна.

Үүнтэй холбоотой байгууллагын одоогийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай байна.
Тус цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тайлант хугацаанд 79,490.2

УВС АЙМАГ ЛАХЬ ТӨРИЙН АУЛИТЫН ГАЗАР

Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ийн АУДИТОР

 /М.БАЯЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 13 ны өдөр

